



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2014 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 89

Улаанбаатар хот

“Борнуур” ХК-ийн үнэт цаасны  
бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 06 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 20 дугаар зүйл, Баянгол дүүргийн шүүхийн 2007 оны 155 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Борнуур” ХК-ийн нийт гаргасан 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 561,934 /таван зуун жаран нэгэн мянга есөн зуун гучин дөрөв/ ширхэг энгийн хувьцаанаас 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 363,965 /гурван зуун жаран гурван мянга есөн зуун жаран тав/ ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасч, тус хувьцаат компанийн гаргасан нийт энгийн хувьцааг 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 197,969 /нэг зуун ерэн долоон мянга есөн зуун жаран ес/ ширхэгээр тогтоосугай.

2. Тогтоолын 1 дэх заалтын дагуу 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 363,965 ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/, Хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Болормаа/, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан хууль тогтоомжийн дагуу холбогдох өөрчлөлтийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн Хороонд хувийг ирүүлэхийг “Борнуур” ХК /Ш.Даваажав/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН



000091